



Яаралтай тусламжийн
нэгжийн ажиллах
журам

СҮАЖ-ЯТНАЖ-010

Хувилбар: 1

Тушаал № *1156*

БАТБАВ
ГҮРЦЭГЭРЭХ ЗАХИРАЛ

Хавсралт №7

М.Ганбаатар

Баталсан огноо: 2019 оны 11 сар 22 өдөр



ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	<i>[Signature]</i>	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	<i>[Signature]</i>	Ч.Золтой	Үйлдвэрийн ахлах эмч	



Яаралтай тусламжийн
нэгжийн ажиллах
журам

СҮАЖ-ЯТНАЖ-010


Хувилбар: 1

Тушаал № *1156*



ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	<i>[Signature]</i>	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	<i>[Signature]</i>	Ч.Золтой	Үйлдвэрийн ахлах эмч	

	Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТНАЖ-010	БАТЛАВ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ /...../ М.Ганбаатар
		Хувилбар: 1	Баталсан огноо: 2019 он сар өдөр
		Тушаал №	

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН НЭГЖИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Ажилтан	Гарын үсэг	Овог нэр	Албан тушаал	Төлөв
Хянасан:	/...../	Д.Батбаатар	ХАБЭА-н хэсгийн дарга	Тэмдэг
Боловсруулсан:	/...../	Ч.Золтой	Үйлдвэрийн ахлах эмч	

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

БАРИМТ БИЧГИЙН ТҮҮХ			
Хувилбар	Өөрчлөлтийн утга	Боловсруулсан	Тушаалын дугаар/Огноо
1			

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

Агуулга

Нэг. Зорилго	4
Хоёр. Хамрах хүрээ	4
Гурав. Нэр томъёоны тайлбар	4
Дөрөв. Үйл ажиллагааны тухай	4
Тав. Хориглох зүйлс	7
Зургаа. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зааварчилгаа	7
Долоо. Хариуцлага	7
Найм. Хавсралт	7

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

Нэг. Зорилго

1.1. Энэхүү журмын зорилго нь яаралтай тусламжийн нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журам нь “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа үндсэн болон гэрээт компанийн ажилтан бүрд нэгэн адил хамаарна.

Гурав. Нэр томъёоны тайлбар

3.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

3.1.1. Эмнэлгийн яаралтай тусламж гэдэгт хүний амь насанд аюултай аливаа эмгэгийг оношлох, эмчлэх, түүнийг сэхээн амьдруулах, хүндрэлээс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн дангаар болон эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй хамтран гүйцэтгэх хойшлуулшгүй үйл ажиллагааг ойлгоно.

3.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэдэгт хүний өвчин, эмгэг, гэмтлийг илрүүлэх, оношлох, магадлах, илааршуулах, сэргээн засах, сэргийлэхэд чиглэгдсэн эмч, эмнэлгийн бусад мэргэжилтний дангаар буюу хамтран гүйцэтгэх үйл ажиллагааг ойлгоно.

3.1.3 Яаралтай тусламж үзүүлсэн тухай мэдэгдэх гэдэг нь хүний амь насанд аюултай аливаа осол гэмтэл, өвчин эмгэгийн үед биеийн байдал, хүндрэл, цаашид авах арга хэмжээний талаар шийдвэр гаргаж, холбогдох албан тушаалтанд электрон шуудан, бичгээр мэдээлэл хүргэхийг хэлнэ.

3.1.4 Ажлын байранд хийх эмчийн урьдчилан сэргийлэх үзлэг гэдэгт биеийн ерөнхий үзлэг хийж, амин чухал үзүүлэлтийг үзэх, хянахыг ойлгоно.

3.1.5 Эмчлэх гэдэгт өвчнийг оношлох, илааршуулах, өвчтнийг сэргээн засах, өвчлөхөөс сэргийлэхэд чиглэгдсэн эмчийн мэргэжлийн цогц үйл ажиллагааг ойлгоно.

Дөрөв. Үйл ажиллагааны тухай

4.1. Компанийн удирдлагын үйл ажиллагаа

4.1.1. Компани нь үйлдвэрт байрлах яаралтай тусламжийн нэгжийг шаардлагатай эм, тариа, багаж, техник, тоног, төхөөрөмжөөр иж бүрэн хангана.

4.1.2. Компанийн удирдлага 24 цагийн туршид яаралтай тусламжийн нэгжийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад шаардагдах эмнэлгийн мэргэжлийн боловсон хүчинг хүрэлцээтэй байлгана.

4.1.3. Компанийн удирдлага нь ЯТН-ийн санал, санаачлагыг хүлээн авч, танилцана.

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

4.1.4. Хүний нөөцийн мэргэжилтэн нь ажилтныг ажилд ороход нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах хуудас өгч эмнэлгийн үзлэг, шинжилгээний дүгнэлт гаргуулсны дараа ажиллуулна.

4.1.5. Компаний хэмжээнд эмнэлгийн яаралтай тусламжийг үзүүлэх багууд нь үйлдвэрийн яаралтай тусламжийн кабинет, байранд байрлах байдлаар зохион байгуулагдана.

4.2. Яаралтай тусламжийн нэгжийн үйл ажиллагаа

4.2.1. Эмнэлгийн яаралтай тусламжийг компаний үйлдвэрийн үйл ажиллагаанд оролцож буй үндсэн болон гэрээт компаний ажилтнуудад үзүүлнэ.

4.2.2. Гэнэтийн ослын үед гэмтэл, бэртэл авсан мөн цочмог өвчнөөр өвчилсөн ажилтанд эмнэлгийн анхны тусламж үзүүлж, шаардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт хүргэнэ.

4.2.3. Яаралтай тусламж үзүүлсэн тухай хавсралт №2-оор мэдээлнэ.

4.2.4. Эмч нар анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм, тарианы чанар, аюулгүй байдал, зарцуулалтанд хяналт тавьж тэдгээрийн бэлэн байдлыг хангаж ажиллана. Зонхилон тохиолдох өвчлөлийн эрт үеийн оношлогоо, эмчилгээг хийх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.2.5. Эмнэлгийн яаралтай тусламжид шаардагдах эм, тариа, багаж материалын жагсаалтыг энэ журмын нэгдүгээр хавсралтаар батлуулж мөрдөж ажиллана.

4.2.6. Эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээний тухай 135-р тогтоол, бусад холбогдох хууль, дүрэм, журмыг баримтлан ажиллана.

4.2.7. Ажлын бэлэн байдал хангах үзлэгийг 7 хоногт 2 удаа чанартай сайн гүйцэтгэж, ажилтны биеийн ерөнхий байдалд үнэлгээ өгч, шаардлагатай тохиолдолд ажлаас түр чөлөөлж, холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ.

4.2.8. Ажилд бэлэн байдлыг хангах үзлэгээр удаа дараа ажилд тэнцэхгүй байгаа ажилтныг хяналтанд авч, эрүүлжүүлэх болон ажлыг байрыг солих арга хэмжээ авна. Өвчтөний эмчилгээний үр дүнг хянах, нарийн мэргэжлийн эмчид хандах шаардлагыг тодорхойлно.

4.2.9. Урьдчилан сэргийлэх үзлэгээр заагдсан эмчилгээг ажилтан цаг хугацаандаа хийлгэсэн эсэхэд хяналт тавьж шаардлагатай бол ажил амралтын зохицуулалт хийх талаар хүний нөөцийн ажилтанд зөвлөгөө өгнө.

4.2.10. Аливаа халдвар гарсан тохиолдолд голомтын халдваргүйтгэлийн ажлыг шуурхай зохион байгуулж, биечлэн оролцоно.

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

4.2.11. Ажилтнуудын үзлэг, шинжилгээ, эмчилгээ зэрэгт тогтмол бүртгэл хөтөлж хадгалах, эдгээрт дүн шинжилгээ хийж тайлагнана.

4.2.12. Эмчийн заавраар сувилахуйн тусламжийг стандартын дагуу чанартай, шуурхай үзүүлэх, ороох боох материалыг бэлтгэх, дефибриллятор, зөөврийн гэрэл, ариутгасан багаж болон эмчийн цүнх зэргийг байнгын бэлэн байдалд байлгаж ажиллана.

4.2.13. Автоклав болон бусад эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн техникийн паспортыг тогтмол хөтлөх, хийгдсэн эмчилгээ, тарилгаас үүссэн эмнэлгийн тусгай хог хаягдлыг журмын дагуу тогтмол устгаж, тэмдэглэл хөтөлнө.

4.2.14. Үйлдвэрийн бүсийн замын гарц, хөдөлгөөний чиглэл, хаалт хашилт болон зам засварын ажлын судалгааг тогтмол хийж мэдээлэлтэй байна

4.2.15. Эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлага ирсэн үед хэрэв эмнэлгийн машин техникийн үйлчилгээ, үзлэгт орох болон өөр бусад нөхцөлөөс шалтгаалан бэлэн биш тохиолдолд яаралтай тусламж үзүүлэх баг үйлдвэрийн ямар ч техник тоног төхөөрөмж, машиныг дайчлан ослын газар хүрэлцэн очиж, шаардлагатай тээвэрлэлтийг хийж болно.

4.3. Ажилтны эрүүл мэнд

4.3.1. Ажилтан нь үйлдвэрийн нөхцөлд ажиллахаар ирэхдээ, ажлын бэлэн байдлыг хангаж, ариун цэвэр, хооллолт, ажил, амралтын дэглэмийг зохицуулж, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлж өөрийн эрүүл мэнддээ анхаарч ажиллана.

4.3.2. Ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамрагдах ба үзлэгээр илэрсэн өвчнийг эмчлэх, эрүүлжүүлэх, эмчийн заавар зөвлөгөөний дагуу эмчилгээ, сувилгаа хийлгэнэ.

4.3.3. Өвчин эмгэгийн улмаас мөн урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэж байгаа эм, тариа, хүнсний нэмэлт бүтээгдэхүүний талаар яаралтай тусламжийн нэгжийн эмч нарт мэдээлнэ.

4.3.4. Ажиллах хугацаандаа өвчилсөн бол, эмчийн шийдвэрээр шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамрагдана.

4.3.5. Ажилтан ажилд гарахын өмнө, ажиллах явцад ямар нэгэн зовиур илэрвэл яаралтай тусламжийн нэгжийн эмчид хандаж, дуудлага өгнө.

4.3.6. Ажилтан ослын талаар мэдээлэхдээ осолдогчийн биеийн байдал, байрлал, гэмтлийн төрөл зэргийг тодорхой, үнэн зөв танилцуулна.

4.3.7. Амралтын хугацаанд бэртэж гэмтсэн, халдварт өвчнөөр өвчилсөн, сэтгэл санаа бие махбодийн байдал гүнзгий хямарсан байгаа зэргийг ээлжийн эмч нартаа заавал урьдчилан

Яаралтай тусламжийн нэгжийн ажиллах журам	СҮАЖ-ЯТАЖ-010
	Хувилбар: 1

мэдээлж, зөвлөгөө авч, ажилдаа ирэх эсэхээ шийдвэрлүүлнэ. Нарийн мэргэжлийн эмчийн заавраар эмчилгээ хийлгэж байгаа бол эмчийн бичгийг үзүүлэн үргэлжлүүлэн эмчилгээгээ хийлгэж болно.

Тав. Хориглох зүйлс

5.1. Осол гэмтэл, цочмог үрэвсэлт өвчнүүдийн үед эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх үйл явцыг мэргэжлийн түвшинд яаралтай тусламжийн нэгжийн эмч нар шийдвэр гаргаж, арга хэмжээ авах бөгөөд, мэргэжлийн бус ажилтан, албан тушаалтан энэ үйл ажиллагааг саатуулах, байцаах, цаг алдуулах, зааварчлахыг хориглоно.

5.2. Эм барих тусгай зөвшөөрөлгүй эмнэлгийн мэргэжилтэн ажилтанд эм ,тариа зарж борлуулахыг хориглоно.

5.3. Эмнэлгийн тусламж, эмийн болон эмийн бус эмчилгээг зөвхөн эмчийн шийдвэрээр хийх ба ажилтан өөрөө дур мэдэн шаардахыг хориглоно.

Зургаа. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зааварчилгаа

6.1. Эмч нар мэдлэг чадвараа байнга дээшлүүлэх, өөрийгөө тасралтгүй хөгжүүлнэ.

6.2. Эрүүл мэндийн байгуулагуудтай хамтран ажиллана.

6.3. Сургалтын төлөвлөгөөний дагуу улиралд нэг удаа ажилтнуудад эрүүл мэндийг хамгаалах, өвчнөөс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх, мэргэжлээс шалтгаалах өвчин зэрэг чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулна.

Долоо. Хариуцлага

7.1. Энэ журмын үүрэг болгосон болон хориглосон аливаа заалтыг зөрчсөн ажилтан, албан тушаалтанд Монгол Улсын холбогдох хууль, Компанийн Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээнд заасан хариуцлагыг хүлээлгэхийн зэрэгцээ Компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хүртэл арга хэмжээ авна.

Найм. Хавсралт

8.1. Хавсралт 1. Яаралтай тусламжид хэрэглэх зайлшгүй шаардлагатай эм хэрэгслийн жагсаалт / Эрүүл мэндийг хамгаалах дэд хөтөлбөр, хавсралт 9/

8.2. Хавсралт 2. Яаралтай тусламжийн рапорт